



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.01.02 № 03/01
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД**


Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжийг үүгээр хүргүүлж байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АМГАЛАН



1110200003



١٣٢٨ هـ : ١٩٠٦ م

• **مراجعة المسائل** : ١٢١١

006900 : حکم و مشورۃ

ᠮᠣᠩᠭᠤᠯ ᠨᠢᠶ᠋ᠣᠳᠦ : www.uiaanbaatar.mn

04/05/2022

مس 9 و مس 9

وَلَقَدْ أَهْلَكْنَا مَا بَيْنَ يَدَيْهِمْ وَآخِرَهُمْ بِمَا كَانُوا يَعْمَلُونَ

تختیار سے جس طرح منتخب کیا گیا ہے وہ 60 قسری
میں 100 و بعض میں 1000 ہے، » فقہیہ و مستقیمہ گام
لے کر ہیتمہ منتخب و معین « 60 قسری درختیہ کن
مستقیمہ ..

.. ಹೆಚ್. ಜಿ. ಅಮೃತೇಶ್



॥ Information ॥

ה'תשנ"ח

111020001



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 18/01

Улаанбаатар хот

2025 оныг “Бүтээн байгуулалтын жил”
болгон зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7, 8.3.14 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.1, 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг “Нийслэлийн бүтээн байгуулалтыг дэмжих жил”-ээр зарласантай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласугай.

2. “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг дэмжиж, шинэлэг шийдэл, инноваци, технологи шингээсэн, стандартад нийцсэн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, нийгмийн хөгжил, иргэдийн амьдрах орчныг сайжруулах үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Т.Даваадалай)-т даалгасугай.

5. “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үр дүнг улирал тутам Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Ажлын хэсэг (Т.Даваадалай)-т, жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчлан ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Баярцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200001

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
01 дугаар сарын 02-ны өдрийн
А/01 дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч.

Гишүүд:

Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн зөвлөхүүд;

Нийслэлийн Ерөнхий архитектор;

Багануур дүүргийн Засаг дарга;

Багахангай дүүргийн Засаг дарга;

Баянгол дүүргийн Засаг дарга;

Баянзүрх дүүргийн Засаг дарга;

Налайх дүүргийн Засаг дарга;

Сүхбаатар дүүргийн Засаг дарга;

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;

Чингэлтэй дүүргийн Засаг дарга;

Хан-Уул дүүргийн Засаг дарга;

Бодлогын судалгаа шинжилгээний төвийн дарга;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын газар, хэлтсийн дарга нар;

Улаанбаатар хотын Захирагчийн албаны газар, хэлтсийн дарга нар;

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дарга нар;

"Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын дарга;

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын дарга;

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал.

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга.

فصل ۱۰

۲۵۰۰۰۰ ریال ۲۵۰ ریال ۲۵۰ ریال

وہیں کہیں کہیں

[illegible]

[illegible][illegible]